

2025 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэмжих нэгж	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Улирал				2025.12.15 байдлаар		Гүйцэтгэлийн хувь
						I	II	III	IV	Гүйцэтгэл		
Стратеги төлөвлөгөөний зорилго 1: Биржийн зах зээлийн зохицуулалт, эрх зүйн орчинг сайжруулах												
Дэд зорилт 1.1. Биржийн зах зээлийг боловсронгуй болгох зорилгоор холбогдох хууль, журам, төрийн бодлого төлөвлөлтийн харилцан уялдаа холбоог бий болгоно.												
1.1.1	Биржийн үйл ажиллагаанд хамаарах хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй богино, дунд, урт хугацааны бодлого төлөвлөлт, хөтөлбөр, хөдөлгөөний хэрэгжилтийг хангах үе шат бүхий төлөвлөгөө гарган, хэрэгжилтийг ханган ажиллах;	хувь	Баримт бичиг	0%	100%					1. ТУЗ-өөр батлуулсан компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг үйл ажиллагааны чиг хүрээ, хариуцах ажилтан, гүйцэтгэх хугацаа тус бүрээр нь нарийвчлан гаргаж Гүйцэтгэх захирлаар батлуулан мөрдөн ажиллаж байна. Мөн хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй богино, дунд, урт хугацааны бодлого төлөвлөлт, хөтөлбөр, хөдөлгөөнүүдийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд биржийн үйл ажиллагаанд хамаарах ажил үүргийг тодорхойлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2. МУИХ-ын 2024 оны "Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай" 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах талаар МУИХ-ын БОХХААБХорооны 2025 оны 09 дүгээр тогтоол, МУЗГ-ын 2025 оны 19 дүгээр хуралдааны тэмдэглэлд тусгасан зах зээл дээрх ноолуурын худалдан авалтыг дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор жилийн 12 хувийн хүүтэй 500.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний энгийн вексель гаргах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ноолуурын бэлтгэлийг хангуулах, үйлдвэрлэлийг дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр түүхий эд худалдан авалтын санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, түүнийг мөнгөжүүлэх, эргэн төлүүлэхтэй холбогдсон асуудлаар ХХААХҮЯ, Монголбанк, "Хөдөө аж ахуйн бирж" ХХК, "Монголын ноос, ноолуурын холбоо" ТББ, Үндэсний үйлдвэр, Арилжааны банкууд хамтран ажиллаж, ХХААХҮЯ, "Голомт банк", "Ханбогд кашимер" ХХК болон "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн хооронд 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 250623/06-573/974 дугаартай 7 тэрбум төгрөгийн "Ноолуурын худалдан авалтыг дэмжиж, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх дөрвөлсөн гэрээ"-г, ХХААХҮЯ, "Голомт банк", "Говь" ХК болон "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн хооронд 2025.06.23-ны өдрийн 250623/06-574 дугаартай 7 тэрбум төгрөгийн "Ноолуурын худалдан авалтыг дэмжиж, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх дөрвөлсөн гэрээ" болон 2025.08.15-ны өдрийн 250623/06-574-1 дугаартай боловсруулах үйлдвэрээс самнасан ноолуур худалдан авах тухай дөрвөлсөн гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлтийн төслийг боловсруулан эцэслэж, талууд гарын үсэг зурж баталгаажууллаа. Хөдөө аж ахуйн бирж нь тус арга хэмжээнд векселиэр худалдан авсан ноолуурын баталгаажуулалт, бүртгэлд хяналт тавих үүргээр оролцсон бөгөөд "Говь" ХК-ийн худалдан авсан ноолуурт хяналт тавьж, баталгаажуулалтыг гэрээний хавсралт маягтын дагуу гүйцэтгэн Голомт банк руу цаг тухай бүр эх хувиар хүргүүлэн ажилласан. "Говь" ХК нь "Ноолуурын худалдан авалтыг дэмжиж, самнасан ноолуурын экспортыг нэмэгдүүлэх чиглэлээр санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх дөрвөлсөн гэрээ"-нд заасан хугацаанд төлбөрийн 100% төлж гэрээг хаасан.	100%	
Дэд зорилт 1.2. Биржийн үйл ажиллагааны дүрэм, журмыг шинэчлэн найруулж, олон улсад мөрдөгддөг зарчим болон стандартыг өөрийн улсын онцлогт нийцүүлэн боловсруулна.												
1.2.1	Биржийн одоогийн мөрдөж буй дүрэм, журмын хэрэгжилтийн үнэлгээг гаргаж, хэрэгжүүлэх боломжгүй болон хэрэгжилт хангалтгүй зүйл, заалтыг тодорхойлон, шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх;	хувь	Баримт бичиг	0%	100%					Гүйцэтгэх захирлын 2025. 10.31-ний өдрийн А/64 дүгээр тушаалаар утга агуулгын хувьд хуучирч, зохицуулах харилцааны шаардлага хангахгүй болсон, шинэчлэн батлагдсан хэдий ч хүчингүй болгох заалт ороогүй зарим журмуудыг хүчингүй болгов. "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-д одоогийн байдлаар нийт 23 журам мөрдөгдөж байна.	100%	
Дэд зорилт 1.3. "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай" хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулна.												
1.3.1	"Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай" хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг эцэслэн батлуулах, Монгол Улсын Засгийн газрын гишүүдээс санал авч, Улсын Их Хурлаар хэлэлцүүлж, батлуулахад өргөн барих эрх бүхий этгээдэд дэмжлэг үзүүлж ажиллах;	тоо	Баримт бичиг	0	1					"Хөдөө аж ахуйн биржийн тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг боловсруулан, УИХ-ын Үйлдвэржилтийн байнгын хорооны 2022.03.03-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Хуулийн үзэл баримтлалын хүрээнд бусад хууль тогтоомжид нийцүүлэн "Хөдөө аж ахуйн биржийн тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 7 бүлэг, 25 зүйлтэй байхаар боловсруулаад байгаа бөгөөд "Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөний үнэлгээ, зардлын тооцоо"-г Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран гүйцэтгэсэн. "Хөдөө аж ахуйн биржийн тухай" хуулийн шинэчилсэн найруулгын төслийг цаашид ХХААХҮЯ-ны БТГ хариуцан гүйцэтгэхээр тогтож холбогдох материалыг биржээс шилжүүлэн авсан болно. Тус хууль нь нийтээр дагаж мөрдөх эрх зүйн баримт бичиг тул хуулийн хэрэгжилтэд хамаарах төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, арилжааны зах зээлд оролцогч иргэн, аж ахуйн нэгжүүдээс хуулийн төсөлд санал авч байна. Одоогоор МҮХАҮТ-аас хуулийн төсөлд санал ирсэн байгаа бөгөөд бусад арилжааны зах зээлд оролцогчдоос санал ирсэний дараа түүнийг ХХААХҮЯ-ны БТГ нэгтгэн бэлтгэж, ХХААХҮ-ийн Сайдын тушаалаар баталсан ажлын хэсэг байгуулагдан хэлэлцүүлэг өрнүүлж, УИХ-ын чуулганаар өргөн мэдүүлэхээр төлөвлөж байна.	100%	
Стратеги төлөвлөгөөний зорилго 2: Биржийн бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг сайжруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх												
Дэд зорилт 2.1. Биржийн онцлогт тулгуурласан бүтэц зохион байгуулалтыг оновчтой тодорхойлж, бүтцийн шинэчлэл хийж, ажлын үр дүнг нэмэгдүүлнэ.												
2.1.1	Үндэсний итгэмжлэлийн төвд "Баталгаажуулалтын байгууллага" болохоор итгэмжлүүлэх хүсэлтийг хүргүүлэх /MNS ISO/IEC 17065:2013 стандарт нийцүүлэх/;	тоо	Баримт бичиг	0	1					Хөдөө аж ахуйн бирж ХХК-ийн бүтэц, орон тоо шинэчлэн батлагдаагүй байгаа бөгөөд одоогийн байгаа хүний нөөцөд мэргэжлийн боловсон хүч дутагдалтай байна. Иймд МУЗГ-ын 2022 оны 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор "Монголын ноос, ноолуурын холбоо" ТББ-тай байгуулсан санамж бичгийн гэрээний хэрэгжилтийн хүрээнд ноолуур, хонины ноос, завод ноосонд MNS ISO/IEC 17065:2013 стандартын дагуу баталгаажуулалтыг хийлгэж байна. 2025.06.17-12.15-ны өдрийн байдлаар 124 аж ахуйн нэгжийн 1933.5 тн хонины угаасан ноос, 1031.5 тн самнасан ноолуур, 128.9 тн завод ноосны баталгаажуулалт хийгдээд байна.	100%	
2.1.2	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 218 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд бэлтгэл ажил хангах, хувьцаа эзэмшигч болон эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллах;	хувь	Хэрэгжилт	0%	100%					МУЗГ-ын 2024.05.22-ны өдрийн "Хөдөө аж ахуйн бирж" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн талаар авах арга хэмжээний тухай 218 дугаар тогтоолоор Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулах хүрээнд "Хөдөө аж ахуйн бирж" ТӨХХК-ийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулах, төрийн эзэмшлийн хувьцаа 34 хувь байх хэмжээнд нэмэлт хувьцаа гарган биржээр олон нийтэд нээлттэй худалдах бэлтгэл ажлыг хангах, холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосон. Үүний хүрээнд "Хөдөө аж ахуйн бирж" ХХК нь Компанийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан мэдээнд үндэслэн Бизнесийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээ, Хууль зүйн дүгнэлт гаргах зөвлөх үйлчилгээ, Санхүүгийн тайлангийн аудитын зөвлөх үйлчилгээ, Андеррайтерийн компанийн зөвлөх үйлчилгээгнүүдийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу шалгаруулан гэрээ байгуулан хамтран ажилласан бөгөөд эдгээр байгууллагуудад компанийн санхүү болон үйл ажиллагаатай холбоотой баримт бичгүүдийг гарган өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэгч андеррайтерийн компанид "Хөдөө аж ахуйн бирж" ТӨХХК-ийн 2025-2030 оны "Бизнес төлөвлөгөө"-г бэлтгэж хүргүүлсэн. Хөдөө аж ахуйн биржийн Хувьцааны үнэт цасны танилцуулгын төслийг 2024.11.29-ний өдөр Андеррайтерийн компаниас хүлээн авч, ТУЗ-ийн 2024.11.13-ны өдрийн 26 дугаар тогтоолын хавсралтаар батлуулсан. 2025 онд Төрийн өмчийн компаниудын засаглалыг сайжруулах, ил тод байдлыг хангах, нээлттэй хувьцаат компани болгох ажлын хүрээнд ТӨБЗГ-аас Төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн "2026-2028 оны Үндсэн чиглэл болон IPO"-ны танилцуулгыг бэлтгэн МУЗГ-т танилцуулж, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	100%	
Дэд зорилт 2.2. Боловсон хүчний бодлого, төлөвлөлт, нийгмийн оролцоо, хувь хүний хөгжил, цалин урамшуулал, идэвхжүүлэлт бүхий биржийн хүний нөөцийн цогц бодлого, төлөвлөлтийг төсөө болон санхүүгийн төлөвлөгөөнд тулгуурлан 1 болон 5 жилээр боловсруулж, хэрэгжүүлнэ.												
2.2.1	"Хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-т заасны дагуу хүний нөөцийг мэргэшүүлэх, чадавхжуулах, хөгжлийн тогтолцоог боловсронгуй болгох үндсэн бодлогыг баримталж, хувь хүний мэдлэг, туршлага, ур чадварыг үндэслэн хүний нөөцийн сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтууд зохион байгуулах;	тоо	Арга хэмжээ	0	8					"Хүний нөөцийн бодлогын баримт бичиг"-т заасны дагуу хүний нөөцийг мэргэшүүлэх, чадавхжуулах, хөгжлийн тогтолцоог боловсронгуй болгох үндсэн бодлогыг баримталж, хувь хүний мэдлэг, туршлага, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор хүн тус бүрээс сургалтын хэрэгцээ шаардлагын саналыг нэг бүрчлэн авч, тухай бүрт нь сургалтад хамруулах ажлыг эхлүүлээд байна. 2025 оны эхний хагас жилд 24 сургалтад нийт ажилтнууд хамрагдаад байна.	100%	

2.2.2	“Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын “2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамыг түүний харьяа байгууллагуудын хамт Дархан-Уул аймагт нүүлгэн шилжүүлэхтэй холбогдуулан ажлын байрны таатай орчин нөхцлийг тухайн жилийн Төлөөлөн удирдах зөвлөлөөр баталсан жилийн төсөвт багтаан бүрдүүлэх;	хувь	Хэрэгжилт	0%	100%				“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн оффисын байранд уулзалтын хэсэг, ажилтнууд амрах хэсэг, цайны хэсэг, хурал уулзалт хийх ухаалаг дэлгэц, зөөврийн компьютер, ахуйн хэрэглээний зүйлс зэргээр бүрэн хангаж, ажиллахад таатай байхаар тохижуулан, ажлын байрны орчин нөхцлийг таатай байхаар бүрэн ханган ажиллаж байна.	100%
Дэд зорилт 2.3. Байгууллагын санхүүгийн удирдлага, төлөвлөлт, ашигт ажиллагааг хангах, хөрөнгө оруулалтын өгөөжийг тогтвортой байлгаж, эрсдэлийн удирдлага, хяналт шинжилгээг хэрэгжүүлнэ.										
2.3.1	Байгууллагын хөгжлийн зорилго, урт болон богино хугацааны төлөвлөгөөнд үндэслэн зорилтот түвшний төсвийг төлөвлөх, мөнгөн урсгалын менежментийг сайжруулах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх;	хувь	Арга хэмжээ	0%	100%				ХХААХҮЯ болон түүний харьяа байгууллагууд Дархан-Уул аймагт шилжин суурьшсан. Үүнтэй холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайд буюу Хувьцаа эзэмшигч, ТҮЗ-ийн хурлын шийдвэрээр Компанийн мөнгөн хөрөнгөд томоохон өөрчлөлт гарч, мөнгөн хөрөнгийн нөөц эрс буурсан. Үүнтэй холбогдуулан Гүйцэтгэх захирал болон Төлөөлөн удирдах зөвлөд нөхцөл байдлын талаар цаг тухай бүрт нь мэдээлэл өгч, мөнгөн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, ажилтнуудын цалин хөлсийг цаг тухай бүрт нь тасалдуудахгүй олгох, төлөвлөгөөнд тусгагдсан, зайлшгүй шаардлагатай зардлуудыг санхүүжүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна.	100%
2.3.2	Арилжааны шимтгэлийн хувь хэмжээ, гишүүнчлэлийн хураамж, элсэлтийн хураамж, суудлын хураамж, итгэмжлэгдсэн этгээдийн хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох шаардлагатай бол тухай бүр нарийвчлан тооцоолох, холбогдох этгээдэд танилцуулах;	хувь	Хэрэгжилт	0%	100%				МУЗГ-ын 2022 оны “Техникийн зохицуулалт батлах тухай” 380 дугаар тогтоолоор “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт”-ыг 2025.02.01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлэх тухай МУЗГ-ын 2025 оны 46 дугаар тогтоол гарсантай холбогдуулан ТҮЗ-ийн 2025 оны 03 дугаар тогтоолоор биржээр арилжсан самнасан ноолуурын арилжаа, төлбөр тооцооны шимтгэлийн хувь хэмжээг 2025.03.17-ны өдрөөс эхлэн 0.62 хувь байхаар тогтоов. Тайлант хугацаанд гишүүнчлэлийн хураамж, элсэлтийн хураамж, итгэмжлэгдсэн этгээдийн хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох шаардлага үүсээгүй байна.	100%
Дэд зорилт 2.4. Маркетинг, олон нийтийн харилцааг хөгжүүлнэ.										
2.4.1	Биржийн үйл ажиллагааг сурталчлах, таниулах, зах зээлд оролцогчдод зориулсан “Маркетингийн төлөвлөгөө”-г төсөв болон санхүүгийн төлөвлөгөөнд тулгуурлан жил бүр боловсруулж, батлуулах;	тоо	Баримт бичиг	0	1				Компанийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө, 2025 оны Бизнес төлөвлөгөөний дагуу компанийн 2025 оны Маркетингийн төлөвлөгөөг боловсруулж Гүйцэтгэх захирлаар батлуулсан.	100%
2.4.2	Биржийн цахим мэдээллийн хэрэгсэл /www.mse.mn/ болон бусад платформ дахь цахим хуудсуудыг хөгжүүлж, олон нийтийн сүлжээнд маркетингийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хөдөө аж ахуйн салбарт төрөөс хэрэгжүүлж буй богино, дунд, урт хугацааны бодлого төлөвлөлт, хөтөлбөрүүдийг сурталчлан таниулах;	тоо	Хэрэгжилт	0	3				Компанийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд вебсайтад шинэчлэлийн ажлыг эхлүүлсэн ба мэдээ, мэдээллүүдийг цаг тухай бүрт оруулж ажиллаж байна. Үүнд: ковер, баннер зэргийн загварыг шинэчилсэн, цахим гарын авлага, тайланг бэлтгэж оруулсан бөгөөд үрийн болон хүнсний улаанбуудайн дуудлага худалдаа руу шууд нэвтрэх цонх үүсгэсэн. Мөн мэдээ, мэдээллийг зурган контентоор хүргэх зорилгоор инстаграм платформид шинээр профайл үүсгэн хөгжүүлж ажиллаж байгаа бөгөөд твиттер профайлыг хөгжүүлэхээр мөн шинээр үүсгэсэн. Одоогийн байдлаар мэдээ, мэдээллийг энэ улирлаас эхлэн компанийн албан ёсны цахим сүлжээний 4 сүвгээр /фейсбүүк, твиттер, вебсайт, инстаграм/ түгээн хөгжүүлж байна. Эдгээр сүвгуудаар компанийн үйл ажиллагаа, төрөөс хэрэгжүүлж буй богино, урт хугацааны бодлого төлөвлөлт, салбарын мэдээ зэрэг хөтөлбөрүүдийг сурталчлан таниулж байна. Тайлант хугацаанд компанийн албан ёсны цахим хуудсанд нийт 451 мэдээ, мэдээлэл бэлтгэн олон нийтэд түгээж ажилласан бөгөөд хандалтын тоо 1,894,410 болж өссөн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 31 гаруй хувиар өссөн байна. Мөн цахим хуудасны зочилсон хэрэглэгчдийн тоо 32,825 байгаа нь мөн үетэй харьцуулбал 16 хувиар өссөн. Энэхүү үзүүлэлт нь цэвэр органик өсөлт бөгөөд нэмэлт төлбөртэй мэдээ байршуулалгүйгээр нэмж чадсан байна.Мөн компанийн вебсайтыг тогтмол хөгжүүлж, мэдээ мэдээллээр цаг тухай бүрт олон нийтэд хүргэсэн бөгөөд вебсайтын өнгө төрхийг шинэчилэх, харууцыг өөрчлөх, хэрэглэгчдэд мэдээ, мэдээлэлтэй танилцахад хялбар болгох шинэчлэлийн ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
2.4.3	Хөдөө аж ахуйн салбарт төрөөс хэрэгжүүлж буй богино, дунд, урт хугацааны бодлого төлөвлөлт, хөтөлбөрүүдийг олон нийтэд таниулах сургалт зохион байгуулах, танилцуулга видео, гарын авлага боловсруулах, контент хөгжүүлж, түгээх;	тоо	Хэрэгжилт	0	20				Компанийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах зорилгоор контент хөгжүүлэлтийн ажлын хүрээнд нийт 205 мэдээний постерийн эхийг бэлтгэсэн ба 48 видео контент хийж гүйцэтгэн ажиллалаа. Мөн “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор хэвлэмэл гарын авлага, зөвлөмж зэргийг дижитал хэлбэрт шилжүүлэн И-Брошур болгон хийж гүйцэтгэн цахим хуудас болон вебсайтад байршуулсан. Энэ нь хэвлэмэл материалыг дижитал форматтай болгож олон нийтэд шууд гар утас, таблет, компьютероос байгууллагын хэвлэмэл мэдээлэл, танилцуулгыг үзэх боломжтой болгосон. Үүнд: Ноолуур бэлтгэх гарын авлага, Ноос хяргэх гарын авлага, 2024 оны жилийн эцсийн тайлан, 2025 оны хагас жилийн тайлан, Үрийн болон хүнсний улаанбуудайн дуудлага худалдаанд оролцох гарын авлага, компанийн үндсэн танилцуулга, компанийн үндсэн танилцуулга англи хэл дээрх орчуулгыг хийж гүйцэтгэн цахимжуулсан байна.	100%
2.4.4	Хөдөө аж ахуйн салбарт төрөөс хэрэгжүүлж буй богино, дунд, урт хугацааны бодлого төлөвлөлт, хөтөлбөрүүдийг олон нийтэд таниулах олон нийтэд сурталчлан таниулах, брендинг хийх, мэдээллийг тэгш хүртээмжтэй түгээх;	тоо	Хэрэгжилт	0	200				Хөдөө аж ахуйн салбар, компанийн үйл ажиллагаа, төрөөс хэрэгжүүлж буй богино, дунд, урт хугацааны бодлого төлөвлөлт, хөтөлбөрүүдийг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд компанийн албан ёсны цахим хуудсанд нийт 451 мэдээ, мэдээлэл бэлтгэн оруулсан бөгөөд компанийн үндсэн арилжааны мэдээг 7 хоног бүр Bloomberg TV-ээр дамжуулан олон нийтэд түгээж байна. Мөн мэдээллийн цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор ХХААХҮЯ-ны хэвлэл мэдээллийн багтай хамтарч ажиллаж байгаа бөгөөд 7 хоног бүр яамны сүвгээр дамжуулан биржийн онцлох үйл явдлыг хүргэж байна. Мөн салбарын хүрээнд зохион байгуулагдаж буй арга хэмжээ, сургалт судалгаа, олон нийт рүү чиглэсэн үйл явдлуудад компанийн өнгө төрхийг тодорхойлолн, брендингийг хоногшуулах ажлуудыг хэвлэмэл болон дижитал хэлбэрийн бүх контентуудыг бэлтгэж ажилчдын үнэмлэх, танилцуулга, видео танилцуулга, постер зэрэг компанийн нүүр, өнгө төрхийг тодорхойлж байна.	100%
Дэд зорилт 2.5. Биржээр арилжих жагсаалтад орсон бараа, түүхий эдийн арилжааг идэвхжүүлж, шинээр арилжаалах боломжтой бараа, түүхий эдийн нэр төрлийг нэмэгдүүлэн зах зээлийг өргөжүүлнэ.										
2.5.1	Орон нутагт ноолуурын дуудлага худалдаа зохион байгуулах;	тоо	Арга хэмжээ	0	2				МУЗГ-ын 2022 оны “Техникийн зохицуулалт батлах тухай” 380 дугаар тогтоолоор “Ямааны ноолуурын боловсруулалт, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт” 2025.02.01-ний өдрөөс хэрэгжиг эхэлсэнтэй холбогдуулан “Хөдөө аж ахуйн бирж” ХХК орон нутагт түүхий ноолуурын дуудлага худалдаа зохион байгуулаагүй.	100%
2.5.2	Орон нутагт малын арилжаа, дуудлага худалдаа зохион байгуулах;	тоо	Арга хэмжээ	0	2				Тайлант хугацаанд нийт 410.1 сая төгрөгийн 2,142 толгой амьд малын дуудлага худалдааг зохион байгууллаа. Үүнд: МУСҮТ-ийн Сүхбаатар аймагт байгаа хургатай хонь 41, сувай эм хонь 27, ишигтэй ямаа 27, сувай эм ямаа 17 толгой малын 18.4 сая төгрөгийн дуудлага худалдааг 2025.07.02-ний өдөр танхимаар, Дорнод аймгийн Булган суманд байгаа хуц 2, эр хонь 2, хургатай эм хонь 25, сувай эм хонь 51 толгой малын 13.0 сая төгрөгийн дуудлага худалдааг 2025.07.08-ны өдөр цахимаар тус тус зохион байгууллаа. Нийт 192 толгой бог малын 31.4 сая төгрөгийн дуудлага худалдааг зохион байгуулсан байна. Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг дэвсгэрт “Шилмэл мал-2025” малын үзэсгэлэн, дуудлага худалдаагаар Герефорд үүлдрийн 2 толгой бузан бирууны 18.0 сая төгрөгийн, 1 толгой Араб, Англи азаргийн 47 сая төгрөгийн арилжааг амжилттай зохион байгуулсан. Мөн 2025.10.21-нд Увс аймгийн Сагил суманд байгаа МУСҮТ-ийн 100 хурга, 300 эм хонины 32,750,000 төгрөгийн дуудлага худалдаа, 2025.11.05-нд “Халх гол” ҮБББЗ-ны 55 толгой үхрийн 47,602.500 төгрөгийн дуудлага худалдаа, 2025.11.23-нд Завхан аймагт 530 толгой ямааны 59,360,000 төгрөгийн дуудлага худалдаа, 2025.12.06-нд Сүхбаатар аймагт 103 толгой ямаа, 102 толгой хонь, 21 адууны 67,372,500 төгрөгийн дуудлага худалдаа, Дорнод аймагт 643 толгой хонины 106,095,000 төгрөгийн дуудлага худалдааг тус тус зохион байгууллаа.	100%
2.5.3	“Ноолуур”-ын арилжааг идэвхжүүлэх арга замыг тодорхойлж, арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	6,023				Тайлант хугацаанд 924.3 тэрбум төгрөгийн 3,126 тн самнасан ноолуурын арилжааг зохион байгуулсан. МУЗГ-ын 2025 оны 46 дугаар тогтоолоор “Техникийн зохицуулалт батлах тухай” МУЗГ-ын 2022 оны 380 дугаар тогтоолын хэрэгжүүлэх хугацааг 2025.02.01-ний өдрөөс эхлэн мөрдөх болсонтой холбогдуулан биржийн ноолуурын арилжаа удаашралтай явагдаж байна. МУЗГ-ын 2022 оны 380 дугаар тогтоолыг мөрдөн ажиллах зорилгоор биржээр арилжих самнасан ноолуурын гарал үүсэл, чанар стандартыг хангуулахад /MNS ISO/IEC 17065:2013 стандарт баталгаажуулалтыг “Монголын ноос, ноолуурын холбоо” ТББ-аар гүйцэтгүүлэн арилжааг зохион байгуулж байна. Арилжааны өмнөх үе, арилжааны үе, арилжааны дараах үеүүдэд эрсдэл, саатал гараагүй, хэвийн үргэлжиллээ. Зах зээл дээрх ноолуурын худалдан авалтыг дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор жилийн 12 хувийн хүүтэй 500.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний энгийн вексель гаргах арга хэмжээнд Хаан банк, Голomt банкууд оролцохоо илэрхийлж, 2025.06.23-ны өдөр “Ханбогд кашимер” ХХК болон “Говь” ХХК-иудтай тус бүр 7 тэрбум төгрөг, нийт 14 тэрбум төгрөгийн санхүүжилтийг векселиэр баталгаажуулах, төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээг үзгэлсэн. Хөдөө аж ахуйн бирж нь тус арга хэмжээнд векселиэр худалдан авсан ноолуурын баталгаажуулалт, бүртгэлд хяналт тавих үүргээр оролцоо.	100%

2.5.4	"Хонины ноос"-ны арилжааг идэвхжүүлэх арга замыг тодорхойлж, арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	8,257				Тайлант хугацаанд 8.7 тэрбум төгрөгийн 3,848.4 тн хонины ноосны арилжаа зохион байгуулагдсан байна. МУЗГ-ын 2022 оны 380 дугаар тогтоолыг мөрдөн ажиллах зорилгоор биржээр арилжих самнасан ноолуурын гарал үүсэл, чанар стандартыг хангуулахад /MNS ISO/IEC 17065:2013 стандарт баталгаажуулалтыг "Монголын ноос, ноолуурын холбоо" ТББ-аар гүйцэтгүүлэн арилжааг зохион байгуулж байна. Арилжааны өмнөх үе, арилжааны үе, арилжааны дараах үеүүдэд эрсдэл, саатал гараагүй, хэвийн үргэлжилсэн болно. Мөн биржээр арилжих ноосны гарал үүсэл, чанар стандартыг хангуулахад "Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо" ТББ-тай хамтран ажиллахаар "Санамж бичиг" байгуулаад байна.	47.04%
2.5.5	"Тэмээний ноос"-ны арилжааг идэвхжүүлэх арга замыг тодорхойлж, арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	934				Тайлант хугацаанд 14.6 тэрбум төгрөгийн 987.5 тн тэмээний ноосны арилжааг зохион байгуулсан. Арилжааны өмнөх үе, арилжааны үе, арилжааны дараах үеүүдэд эрсдэл, саатал гараагүй, хэвийн үргэлжилсэн болно. Түүхий эдийн хоршооноос үйлдвэрт нийлүүлэх арилжааны шимтгэлийн хувь хэмжээг 3 жилийн хугацаанд чөлөөлөх тухай 2022 оны ТУЗ-ийн тогтоол хүчинтэй хэвээр байгаа болно. Мөн биржээр арилжих ноосны гарал үүсэл, чанар стандартыг хангуулахад "Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо" ТББ-тай хамтран ажиллахаар "Санамж бичиг" байгуулаад байна.	100%
2.5.6	"Ямааны завод ноос"-ны арилжааг идэвхжүүлэх арга замыг тодорхойлж, арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	2,192				Тайлант хугацаанд 38.2 тэрбум төгрөгийн 1,798 тонн ямааны завод ноосны арилжааг зохион байгуулсан. МУЗГ-ын 2022 оны 380 дугаар тогтоолыг мөрдөн ажиллах зорилгоор биржээр арилжих самнасан ноолуурын гарал үүсэл, чанар стандартыг хангуулахад /MNS ISO/IEC 17065:2013 стандарт баталгаажуулалтыг "Монголын ноос, ноолуурын холбоо" ТББ-аар гүйцэтгүүлэн арилжааг зохион байгуулж байна. Арилжааны өмнөх үе, арилжааны үе, арилжааны дараах үеүүдэд эрсдэл, саатал гараагүй, хэвийн үргэлжилсэн болно.	82.0%
2.5.7	"Хонины завод ноос"-ны арилжааг идэвхжүүлэх арга замыг тодорхойлж, арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	30				Тайлант хугацаанд хонины завод ноосны арилжаа хийгдээгүй. Биржээр арилжих завод ноосны гарал үүсэл, чанар стандартыг хангуулахад "Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо" ТББ-тай хамтран ажиллахаар "Санамж бичиг" байгуулаад байна.	0%
2.5.8	"Мал"-ын арилжааг идэвхжүүлэх арга замыг тодорхойлж, арилжааг зохион байгуулах;	хонин толгой	Тоо хэмжээ	0	6,000				Тайлант хугацаанд нийт 410.1 сая төгрөгийн 2,142 толгой амьд малын дуудлага худалдааг зохион байгууллаа.	36%
2.5.9	"Мах"-ыг биржээр арилжих арга замыг тодорхойлж, арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	100				Тайлант хугацаанд нийт 1.1 тэрбум төгрөгийн 96 тонн махны дуудлага худалдааг зохион байгууллаа.	96%
2.5.10	"Тосны ургамал"-ын арилжааг идэвхжүүлэх арга замыг тодорхойлж, арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	5,495				Тайлант хугацаанд 9.9 тэрбум төгрөгийн 5,849 тонн тосны ургамал /шар рапс/-ын арилжааг зохион байгуулсан. 1. 2025 оноос сэлгээнд тариалах тосны ургамал /рапс/-ын дотоодын болон импортын үрийг "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн бүртгэлийн арилжаанд оролцон тариалах, хураасан ургацаас дотоодын үйлдвэрт нийлүүлэх болон экспортолх арилжааг биржээр дамжуулан зохион байгуулахтай холбогдуулан авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагааны зургаглын талаар экспортын зөвшөөрөлтийг аж ахуйн нэгжүүдэд танилцуулга мэдээллийг боловч уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тус уулзалтыг ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Салбарын хяналтын газар, МУЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Ургамал хамгааллын газар болон "Хөдөө аж ахуйн корпораци" ТӨХХК хамтран зохион байгуулж, аж ахуйн нэгжүүдтэй харилцан санал солилцлоо. Хурлаар хэлэлцсэн асуудлыг оролцогчид 100 хувь дэмжиж, хурлын тэмдэглэлд гарын үсэг зуран баталгаажуулсан. 2. Тариалан үйлдвэрлэлийн нэгдсэн систем болох plant.mofa.gov.mn системд тосны ургамал бүртгүүлэх аргын даалгаварыг хийж ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлсэн.	100%
2.5.11	"Хүнсний буудай"-н арилжааг идэвхжүүлэх арга замыг тодорхойлж, арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	1,000				Тайлант хугацаанд нийт 94.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 95,209.12 тонн хүнсний улаанбуудай арилжсан байна.	100%
2.5.12	"Үрийн буудай"-н арилжааг идэвхжүүлэх арга замыг тодорхойлж, арилжааг зохион байгуулах;	тонн	Тоо хэмжээ	0	1,000				Тайлант хугацаанд нийт 19.0 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 12,011.3 тонн хүнсний улаанбуудай арилжсан байна.	100%
2.5.13	"Арьс, шир"-ний арилжааг идэвхжүүлэх арга замыг тодорхойлж, санал боловсруулах;	тоо	Баримт бичиг	0	1				Биржээр арилжих арьс, ширний гарал үүсэл, чанар стандартыг хангуулахад "Монголын арьс ширний үйлдвэрлэлийн холбоо" ТББ-тай хамтран ажиллахаар "Санамж бичиг" байгуулаад байна. "Цагаан алт" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулсан "Арьс ширэн түүхий эд бэлтгэл-2025" төслийн хүрээнд хойд бүс, зүүн бүс, төвийн бүсэд танхимын хэлбэрээр, баруун бүс, говийн бүс, хангайн бүсэд цахим хэлбэрээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, арьс шир бэлтгэл, хадгалалт, түүхий эдийн гэмтэл, анхан шатны гэрээ, чанар хангах талаар мэдлэг мэдээлэл олгох сургалтыг ХХААХҮЯ, "Цагаан алт" ТББ, 35ДС, Аймгуудын ХХААГ-ууд, "Арьс ширэн үйлдвэрлэлийн холбоо" ТББ-тай хамтран хийж, чанар стандарт болон тулгамдаж буй асуудлуудын талаар нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлжээ. Сургалтын дараа хоршоо, үйлдвэрийг холбоосон арьс ширний дуудлага худалдааг зохион байгууллаа. Тайлант хугацаанд 100.7 сая төгрөгийн 4825 ширжгийн арьс ширний дуудлага худалдааг зохион байгуулсан.	100%
2.5.14	"Малын тэжээл"-ийн арилжааг зохион байгуулах арга замыг тодорхойлж, санал боловсруулан туршилтын арилжааг зохион байгуулах;	тоо	Баримт бичиг	0	1				Малын тэжээлийн төрөл, онцлог давуу талыг тодорхойлж, форвард арилжааны онцлог давуу талыг судлан, малын тэжээлийн арилжааны гэрээний төрөл, боцгын хэмжээг тодорхойлов. 14 тоннын 25,840,000 төгрөгийн малын нэмэлт тэжээлийн дуудлага худалдааг зохион байгууллаа.	100%
Дэд зорилт 2.6. Биржийн "Гэрээний стандарт"-ыг сайжруулах замаар зах зээлийн хөрвөх чадварыг дээшлүүлнэ.										
2.6.1	Биржээр арилжих барааны жагсаалтад шинэ бараа, түүхий эдийн нэр төрөл нэмэгдсэн тохиолдолд "Спот гэрээний стандарт"-ыг боловсруулж, хэрэгжүүлэх;	хувь	Баримт бичиг	0%	100%				Гүйцэтгэх захирлын 2025.12.12-ны өдрийн А/72 дугаар тушаалаар шаардлагатай бараа, түүхий эдийн гэрээний стандартыг шинэчлэн боловсруулж баталсан.	100%
2.6.2	Үүсмэл санхүүгийн хэрэгслээр арилжих боломжтой бараа, түүхий эдийг тодорхойлж, "Гэрээний стандарт" загварыг боловсруулах;	тоо	Баримт бичиг	0	1				Хөдөө аж ахуйн биржийн арилжааны жагсаалтад буй бараа, түүхий эдээс "Хүнсний улаанбуудай"-г үүсмэл санхүүгийн хэрэгслээр арилжих боломжтой гэж үзэн "Гэрээний стандарт"-ын төслийг боловсруулсан. Үүсмэл санхүүгийн хэрэгслийн судалгаанаас дүгнэхэд хөдөө аж ахуйн бараа, түүхий эдэд суурилсан үүсмэл үнэт цаас арилжихад дараах үндсэн нөхцөл бүрдсэн байх шаардлагатай байна. Үүнд: - Тухайн санхүүгийн хэрэгслийн арилжаанд оролцогчид буюу мэргэжилтний санхүүгийн хөрөнгө оруулагчид хангалттай олон байх; - Тухайн санхүүгийн хэрэгслийн ханшийн хэлбэлзэл өндөр байх нь үүсмэл үнэт цаасны гэрээ арилжих үндсэн нөхцөл бөлдог; - Тухайн санхүүгийн хэрэгслийн биржийн спот гэрээний арилжаа идэвхтэй явагддаг; - Тухайн барааны чанар стандарт, тээвэр хүргэлт биржийн итгэмжлэгдсэн байгууллагаар хийгддэг байх. Хүргэлтийн гэх мэт бүх төрлийн дэнчингүүд тавигдаж эрсдлийг үр дүнтэй удирдсан байх шаардлагатай. Монгол Улсад өнөөдрийн байдлаар үүсмэл үнэт цаас арилжиж буй бирж байхгүй. Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцогчид цөөн, мэргэжилтний санхүүгийн хөрөнгө оруулагчид тус бирж дээр арилжаанд оролцдоггүй, биржээр арилжигдаж байгаа бараа, түүхий эдийн ханшийн хэлбэлзэл өндөр биш, спот гэрээний арилжаа нь жигдрээгүйгээс сонгодог утгаараа хаагдах боломжгүй зэрэг нь энэ төрлийн үнэт цаас арилжих бэлтгэл ажлыг хангах хараахан цаг нь болоогүйг илтгэж байна. Иймд үүсмэл санхүүгийн хэрэгслийн судалгааг хойшлуулах эсвэл практик орчинд гадны туршлагатай байгууллагаар гүйцэтгүүлэх саналтай байна.	100%
Дэд зорилт 2.7. Клиринг, төлбөр тооцооны олон улсын арга, аргачлалыг нэвтрүүлж, оролцогчдын эрсдлийг бууруулах, төлбөр тооцоог эрсдэлгүй түргэн шуурхай гүйцэтгэх нөхцөлийг бүрдүүлнэ.										
2.7.1	"Спот гэрээ"-ний арилжааны төлбөр тооцоог хялбаршуулах, хурдан шуурхай гүйцэтгэх боломжийг судалж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн сайжруулах;	хувь	Баримт бичиг	0%	100%				"Ай түүлс" ХК-д ажлын даалгавар боловсруулан өгч, "Худалдах, худалдан авах гэрээ"-г тоон гарын үсгээр баталгаажуулах ажил нь тухайн ажлын урсгалыг хөнгөвчлөх зорилготой байна боловч у компанийн гүйцэтгэл нь ажлын шат дамжлагыг нэмэгдүүлсэн, ажлын урсгалыг улам төвөгтэй болгосон тул системд хөгжүүлэлт хийж өөрчлөх шаардлагагүй гэж Гүйцэтгэх захирлын шуурхай хурлаар хэлэлцэн шийдвэрлэсэн болно. Худалдах, худалдан авах гэрээ, Гишүүнчлэлийн гэрээ зэрэг арилжааны зах зээлд оролцогчдод хамаарах гэрээг цахимжуулах боломжтой эсэх талаар "Смарт Контракт Монголиа" ХХК-тай уулзалт хийж, E-Geree.mn платформыг 2025 онд гэрээг цахимаар байгуулах туршилтыг 1 сарын хугацаанд гүйцэтгэж, 2026 оноос Худалдах, худалдан авах гэрээ болон Гишүүнчлэлийн гэрээг цахимаар хийхээр шийдвэрлэсэн болно.	100%

2.7.2	Биржээр үүсмэл санхүүгийн хэрэгсэл арилжих бэлтгэл ажлын хүрээнд клиринг, төлбөр тооцооны олон улсын арга, аргачлалыг нэвтрүүлж, оролцогчдын эрсдлийг бууруулах, төлбөр тооцоог эрсдэлгүй түргэн шуурхай гүйцэтгэхэд зөвлөх үйлчилгээ авах	тоо	Баримт бичиг	0	1					Гүйцэтгэх захирлын 2025 оны А/07 тушаалаар биржийн системийн шинэчлэл хийх, системийн хөгжүүлэлтийн туршлага судлах, архитектур зураглал хийх, ижил төсөөтэй арилжааны системийн талаар судалгаа хийх, үүсмэл санхүүгийн хэрэгсэл арилжих бэлтгэл ажлын хүрээнд Япон улсын ТОКОМ-ын биржтэй холбоо тогтоож, туршлага судлах зорилгоор "И-Гэрээ" ХХК-ийн зөвлөх Т.Гандуламтай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажиллаж байна. Зөвлөх Т.Гандуламын тайланд тусгагдсан Клиринг, төлбөр тооцоо нь олон улсын түвшинд ямар арга аргачлалаар ажиллах, төлбөр тооцоог эрсдэлгүй түргэн шуурхай гүйцэтгэх үйл ажиллагааны зөвлөмжийг нарийвчлан судалсны үр дүнд бирж нь шууд арилжих гэрээ буюу спот арилжааг сонгодог утгаар нь хэрэгжүүлж эхэлсний дараагаар үүсмэл санхүүгийн хэрэгслийн арилжааг нэвтрүүлэх нь зохистой гэдгийг тодорхойлж, тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна.	100%
Дэд зорилт 2.8. Биржийн "Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө"-г боловсруулж, хяналт, мониторингийн тогтолцоог хэрэгжүүлнэ.											
2.8.1	"Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангаж ажиллах;	хувь	Хэрэгжилт	0%	100%					"Эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө 2025"-ыг Эрсдэлийн удирдлагын хорооны бүрэлдэхүүнээр дамжуулан үйл ажиллагааны чиглэл тус бүрээр хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд жилийн эцсийн хэрэгжилт, тайланг боловсруулсан.	100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 3. Биржийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх											
Дэд зорилт 3.1. Төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой харилцан үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлнэ.											
3.1.1	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа төрийн байгууллагуудтай ажлын уялдаа холбоог сайжруулан хамтран ажиллах;	тоо	Хэрэгжилт	0%	100%					ХХААХҮЯ болон түүний харьяа төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулан хамтран ажиллаж байгаа ба бусад цаг үеийн асуудлаар өгсөн үүрэг даалгаврыг хамтран хэрэгжүүлээ. 1. ХХААХҮЯ-ны ГТБХЗГ, СХГ, МУЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг УХГ болон "Хөдөө аж ахуйн корпораци" ХХК-тай хамтран Хөдөө аж ахуйн биржээр үрийн болон хүнсний улаанбуудай, тосны ургамал /rapc/-ын арилжааг тогтмол зохион байгуулах, ургамлын гаралтай түүхий эдийн гарал үүсэл, мөшгих тогтолцоог бүрдүүлэхэд хамтран ажилласан. 2. ХХААХҮЯ-ны ХөҮБХЗГ-тай хамтран "Цагаан алт" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд "Арьс ширэн түүхий эд бэлтгэл-2025" төслийн хүрээнд хойд бүс, зүүн бүс, төвийн бүсэд танхимын хэлбэрээр, баруун бүс, говийн бүс, хангайн бүсэд цахим хэлбэрээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, арьс шир бэлтгэл, хадгалалт, түүхий эдийн гэмтэл, анхан шатны тордолт, чанар хангах талаар мэдлэг мэдээллийг биржийн арилжааны зах зээлд оролцогчдод олголоо. 3. МУЗГ-ын 2025 оны 19 дүгээр хуралдааны тэмдэглэлд тусгасан зах зээл дээрх ноолуурын худалдан авалтыг дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор жилийн 12 хувийн хүүтэй 500.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний энгийн вексель гаргах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан ХХААХҮЯ-ны БТГ, ХөҮБХЗГ-тай хамтран ажилласан. 4. МЭЭГ-ын даргын 2021 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан "Мал эмнэлгийн гэрчилгээний загвар, хэрэглэх заавар"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7 дэх хэсгийн хэрэгжилтийг хангаж ажиллахаар МЭЭГ-тай хамтран ажиллаж, арилжааны мэдээг МЭЭГ-ын баталгаажуулсан Олон улсын мал эмнэлгийн гэрчилгээний мэдээтэй тулган ажилласан. 5. МУЗГ-ын 2022 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт"-ыг мөрдөх ажлын хүрээнд ХХААХҮЯ-ны МААБХЗГ, МУСҮТ, аймгуудын ХХААГ-уудтай хамтран ажилласан. 6. МУСҮТ-тэй хамтран "Амьд малын төвлөрсөн арилжаа"-г Дорнод, Сүхбаатар, Увс аймгуудад цахимаар, Дархан-Уул аймгийн Хонгор суманд "Шилмэл мал-2025"-ыг танхимаар тус тус зохион байгуулан ажиллалаа. 7. ЖДҮГ-тай хамтран "Өсвөр үхэр, хонь бордох аж ахуй байгуулах жишиг төсөл"-ийг хэрэгжүүлсэн. 8. ЖДҮГ-аас зохион байгуулж буй сургалт, арга хэмжээнд Хөдөө аж ахуйн биржийн талаар танилцуулга мэдээлэл олгон хамтран ажилласан.	100%
3.1.2	Төрийн байгууллагуудтай хамтран ажиллах;	тоо	Хэрэгжилт	0%	100%					1. СЗХ-ны 2014 оны 251 дүгээр тогтоолоор баталсан "Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн биржийн үйл ажиллагаанд хяналт тавих журам", Хорооны 2020 оны 179 дүгээр тогтоолоор баталсан "Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам"-ын хэрэгжилтийг хангуулан холбогдох баримт бичгийн бүрдүүлбэрийг илгээсэн. 2. СЗХ-ны даргын батласан журмын дагуу сар, улирлын мэдээ, тайлан болон цаг үеийн асуудлаар тогтоосон хугацаанд мэдээлэл өгч ажиллаж байна. 3. МУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн экспортын, гарал үүслийн, арилжааны мэдээний зөрүүг ариггах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгохтой холбоотой асуудлаар ГЕГ-тай харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах тухай "Хамтын ажиллагааны гэрээ"-ний төслийг бэлтгэж, ХХААХҮ-ийн сайд болон ТҮЗ-ийн даргын гарын үсэг бүхий албан тоотуудыг ГЕГ-т хүргүүлсэн. Хамтын ажиллагааны асуудлаар ГЕГ-ын холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийлээ. Уулзалтаар "Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай" хуулийн хэрэгжилтийг хангах, МУ-ын жилээр гарч, орж буй хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдэд хяналт тавих арга хэмжээнд ГЕГ-тай гэрээ байгуулан хамтран ажиллах боломжийн талаар ярилцаж, санал солилцсон. 4. Зүүн болон баруун аймгуудын ХХААГ-ын удирдагуудтай өвс, хадлан, тэжээлтэй холбоотойгоор бэлчээрийн хазайлттай танилцаж, хэрхэн тэнцвэржүүлэн зохицуулалт хийж аригжаалах талаар цахим уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтаар өвс, хадлан, тэжээлийн зах зээлийн судалгаа, худалдан авах болон зарах талуудын үнэ, тоо хэмжээ, тээврийн нөхцөлийн талаар мэдээлэл судалгааг гаргаж, бэлтгэл ажлыг хангахаар тогтооло. 5. ТБОНӨХ-өөр хийх худалдан авалтыг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан зохион байгуулах ажлын хүрээнд Дархан-Уул аймгийн Худалдан авалтын ахлах мэргэжилтэн Б.Батчимэгтэй уулзалт хийж мэдээлэл, зөвлөгөө авлаа. Уулзалтын хүрээнд аймгийн хэмжээний боловсролын байгууллагууд (ЕБС, СӨБ)-ын хүнсний (мах, ногоо болон бусад хэрэглээний) хэрэгцээ, жилийн хэрэглээний хэмжээ, тоон мэдээлэл, судалгааг боловсруулах талаар санал солилцлоо. 6. ТБОНӨХ-өөр худалдан авалт хийх төндөр шалгаруулалтад шалгарсан аж ахуй нэгж, иргэнийг татвараас хөнгөлөх, чөлөөлөх боломжийг эрэлхийлэн Дархан-Уул аймгийн Татварын газрын дарга Б.Жамсранжавтай уулзалт хийв. Уг уулзалтаар төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авалтад оролцож байгаа аж ахуй нэгж иргэн нь "Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай" хуулийн 13.1.29. "Малчдын хоришоо, малчин, мал бүхий этгээдийн борлуулсан таван хошуу мал, анхан шатны боловсруулалтад ороогүй мах, сүү, арьс шир, ноолуур, хонь болон тэмээний ноос, сарлагийн хөвөөр" үндэслэн татвараас чөлөөлөгдөх эрх үүссэн байна. 8. "Экспортыг нэмэгдүүлж, худалдааг дэмжих" ажлын хэсгийг Тэргүүн шадар сайд бөгөөд ЗЗХ-ийн сайд ахалж байгаа бөгөөд тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд "Хөдөө аж ахуйн бирж" ХХК-ийн Гүйцэтгэх захирал Х.Отгонбаяр хамрагдан ажиллаж байна.	100%

3.2.3	"Хамтран ажиллах санамж бичиг" байгуулсан гадны ижил төстэй үйл ажиллагаа эрхлэгч таваарын биржүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэх арга замыг тодорхойлох;	тоо	Арга хэмжээ	0	3					Хамтран ажиллах санамж бичиг байгуулсан гадны ижил төстэй үйл ажиллагаа эрхлэгч таваарын биржүүдийг нэг бүрчлэн судлан, хамтын үйл ажиллагаа эрхэлж болохуйц биржүүдийг тодорхойлж, хамтран ажиллах чиглэл, хамтын ажиллагааны төлөвлөгөөг боловсруулаад байна. 1. Беларусь улсын биржээс тус улсад зохион байгуулагдах Олон улсын хөдөө аж ахуйн ассоциацийн хуралд оролцох урилга ирүүлсэн хэдий ч бирж оролцох боломжгүй талаар хариу өгсөн. Бусад орнуудтай харилцаа тогтоогоогүй байна. 2. МУ болон Бүгд Найрамдах Узбекистан Улсын ЗГ хоорондын хэлэлцээрийн дагуу мах, махан болон ноос, ноосон бүтээгдэхүүн нийлүүлэх уулзалт БНУУ-д улсад зохион байгууллаа. Энэ үеэр БНУУ-ын Хөрөнгө оруулалт, аж үйлдвэржилт, худалдааны яам, Мал эмнэлгийн газар, Арьс шир, ноос, гутлын үйлдвэрлэлийн холбоо, Нэхмэлийн үйлдвэрлэлийн холбоотой тус тус уулзалт хийж МУ-аас сэврээсэн мах болон махан бүтээгдэхүүн, самнасан ноос болон ноосон бүтээгдэхүүн нийлүүлэх, нэхмэлийн үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний дэлгүүрийг хоёр талд байгуулах, мэргэжилтэн бэлтгэх талаар санал солилцож, харилцан тохиролцов. Уулзалтад МУ-ын талаас ХХААХҮЯ-ны БТГ-ын дарга, МУ-аас БНУУ-д суугаа Элчин сайд, "Биокомбинат" ХХК, "Зээлийн батлан даалтын сан, "Хөдөө аж ахуйн бирж" ХХК, "Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо", "Хүнс комплекс", "Сүхбаатар мах маркет", "Завхан хүнс групп" ХХК-ийн төлөөлөл оролцлоо.	67%
3.2.4	Ижил төстэй үйл ажиллагаа эрхлэгч Таваарын бирж болон агуулах, лабораторийн үйл ажиллагаа эрхлэгч холбогдох аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцах, туршлага солилцох, хамтран ажиллах;	тоо	Арга хэмжээ	0	5					1. Азийн биржүүдийн холбоонд элсэх, гадаадын биржүүдтэй хамтран ажиллах арга хэмжээг эхлүүлэхээр "И-Гэрээ" ХХК-ийн зөвлөх Т.Гандуламтай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулан ажиллаж байна. 2. Австрали улсад "Монгол, Австралийн тогтвортой санхүү, бизнесийн солилцоо" воркшоп уулзалт зохион байгуулагдлаа. Монголын байгалийн өв сангийн ажлын алба, Удирдах зөвлөл, Монголын Тогтвортой Санхүүжилтийн Хөгжлийн Холбоо (ТоС Холбоо), МУ-ын Ерөнхийлөгчийн тамгын газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, "Хөдөө аж ахуйн бирж" ХХК болон арилжааны банкуудын удирдлагуудын төлөөлөөс бүрдсэн баг бүрэлдэхүүн Австрали улсын Сидней хотод "Монгол, Австралийн тогтвортой санхүү, бизнесийн солилцоо" воркшоп уулзалтыг ТоС Холбоотой хамтран амжилттай зохион байгуулж оролцлоо. Мөн Австралийн мах, хөдөө аж ахуйн ханган нийлүүлэлтийн сүлжээний томоохон оролцогч Meat and Livestock Australia байгууллага, Нидерланд улсад төвтэй Австралийн хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Rabobank Australia байранд зочилж, байгаль орчинд ээлтэй тогтвортой хөдөө аж ахуйн санхүүжилтийн бодлого, зээлийн үйл ажиллагаа, үр дүнгийн талаарх туршлагатай танилцлаа. 3. МУ болон Бүгд Найрамдах Киргиз Улсын ЗГ хоорондын хэлэлцээрийн дагуу мах, махан болон ноос, ноосон бүтээгдэхүүн нийлүүлэх уулзалт зохион байгууллаа. БНКУ-ын Усны нөөц, хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрийн яам, Үндэстний Хөрөнгө оруулалтын сан, Киргиз-Азербайжаны хөрөнгө оруулалтын сан, Киргизийн ноосны үндэсний холбоотой тус тус уулзалт хийж МУ-аас мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх тарилга нийлүүлэх, зээлийн батлан даалтын сангийн туршлага солилцох, Касиет зэрмэлийн үйлдвэрийг сэргээх талаар санал солилцож, харилцан тохиролцож тэмдэглэл үйлдэв.	60%
Стратеги төлөвлөгөөний зорилго 4. Мэдээлэл технологийн цахим шинэчлэлт хийх											
Дэд зорилт 4.1. Биржийн дотоод үйл ажиллагаа, арилжаа, клиринг, төлбөр тооцооны хэвийн үйл ажиллагааг хангах тоног төхөөрөмжөөр хангах.											
4.1.1	Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих "Цагаан алт" хөдөлгөөний хэрэгжилтийн хүрээнд биржийн арилжааг зах зээлийн зохион байгуулалтад шилжүүлэх, түүхий эдийн чанар стандартыг сайжруулах, арилжаа, төлбөр тооцоог гүйцэтгэх, өгөгдөл мэдээлэл солилцох, тооцоолол хийх, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэх, үүсмэл санхүүгийн хэрэгсэл арилжих боломж бүхий олон улсын чиг хандлагад нийцсэн технологийн шинэчлэл хийх боломжийг судлах, танилцуулах;	тоо	Баримт бичиг	0	1					Гүйцэтгэх захирлын 2025.03.15-ны өдрийн А/07 тушаалаар иржийн системийн шинэчлэл хийх, системийн хөгжүүлэлтийн туршлага судлах, архитектур зураглал хийх, ижил төсөвтэй арилжааны системийн талаар судалгаа хийх ажлын хүрээнд "И-Гэрээ" ХХК-ийн зөвлөх Т.Гандуламтай зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан. Гэрээний хүрээнд компанийн өнөөгийн байдал, системийн шинжилгээ хийж Гүйцэтгэх захиралд тайлангаа танилцуулсан.	100%
4.1.2	Биржийн дотоод үйл ажиллагаанд ашиглагдах програм хангамжийг сайжруулж, сүлжээний найдвартай байдлыг хангах;	хувь	Хэрэгжилт	0%	100%					Компанийн дотоод, гадаад сүлжээний тоног төхөөрөмж, ажлын компьютер, дотуур холбоо бусад төхөөрөмжийн найдвартай аюулгүй хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаа. Интернет сүлжээний гарцын төхөөрөмж галт хананы албан ёсны лицензийн сунгалтын гэрээг "Ай Ти Зон" ХХК-тай хийж ажиллав. Байгууллагын хэрэглэж буй зөөврийн компьютеруудын хэвийн үйл ажиллагааг улиралд нэг удаа шалгаж байна. Улаанбаатар дахь салбарын интернет сүлжээний гэрээг шинэчилж интернетийн хурд дээр тохиргоо хийлгүүлж дахин байгуулсан байна. Байгууллагын 2025 оны хэрэглээний програм, вирусуны програмын албан ёсны лицензийг худалдан авч ажлын компьютерууд болон зөөврийн компьютерууд, тусгай дэлгэцүүд дээр суулгаж хэвийн ажиллагаанд оруулсан. Хаан банкны "Корпорейт gateway" үйлчилгээ дууссан байсныг гэрээ сунгаж байгуулсан.	100%
4.1.3	"Арилжаа, төлбөр тооцооны их бүрэн систем"-ийн найдвартай, хэвийн үйл ажиллагааг хангах, шаардлагатай сайжруулалт, хөгжүүлэлтийг хийх;	хувь	Хэрэгжилт	0%	100%					Байгууллагын mce.mn домейн хаягны 1 жилийн эрхийн сунгалтыг хийсэн. Тайлант хугацаанд 156 удаагийн цахим арилжаа, 647 хэлцлийг зохион байгуулж амжилттай явуулсан байна. 43 удаагийн арилжааны системийн асуудал үүссэнийг цаг тухай бүрд алдааг яхан зэвсэрлэж байгууллагын үйл ажиллагааны болон бизнесийн эрсдэл, доголдол үүсгэлгүй ажилласан байна. Ажлын өдрийн пүрэв гараг бүр 14:00 цагаас улсын нөөцөд бүрдүүлэх стратегийн улаанбуудайн дуудлага худалдаа, мал, мах, арьс ширний дуудлага худалдааг тус тус амжилттай зохион байгуулсан. Мөн Арилжаа, төлбөр тооцооны системийн 2025 оны ашиглалт үйлчилгээний дэмжих гэрээг "Ай түүлс" ХК-тай хийсэн. Арилжаа, төлбөр тооцооны системийн дундын өгөгдлийн санг шинээр үүсгэж Dbeaver-р хандаж болсон. Биржийн тодорхойлолтыг цахим хэлбэрт шилжүүлж www.export.mofa.gov.mn экспорт, импортын нэг цонхны систем рүү холбох ажлыг хийж байна.	100%
Дэд зорилт 4.2. Цахим шинэчлэлтийг хийх ажлын хүрээнд биржийн дэд бүтцийг хөгжүүлэх, дэд системүүдийг бий болгоход шаардлагатай тооцоо, судалгааг гаргах, боломжит системийг нэвтрүүлнэ.											
4.2.1	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн "Экспортын нэг цонхны систем"-ийн нэвтрүүлэлт, ашиглалт үйлчилгээ;	Үйлчилгээний тоо	Хэрэгжилт	4	29					Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн "Экспортын нэг цонхны систем"-ийн өдөр тутам гарч буй асуудлыг шийдвэрлэж байна. 2025 онд нийт 5348 экспортын хүсэлт бүрэн шийдвэрлэсэн байна. 2025.03.01-ний өдрөөс тус системээр ургамал, үр тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний импортын мэдэгдэл, дамжин өнгөрөх мэдэгдэлийн хүсэлтийг авч эхэлсэн. Энэ хугацаанд импортын мэдэгдлийн гэрчилгээний 1474 хүсэлтийг, дамжин өнгөрөх гэрчилгээний 1015 хүсэлтийг шийдвэрлэгдсэн байна. 2025.03.01-ний өдрөөс ургамал, үр тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүний импортын мэдэгдэл, 2025.05.01-ний өдрөөс мал, амьтны гаралтай түүхий эд үйлчилгээг нэвтрэх эхэлсэнтэй холбогдуулан нийт 78 байгууллагад зөвлөгөө өгч, гадаад зээнтэй 81 байгууллагын нэвтрэх эрх, компани төлөөлөх ажилтныг системд тохируулж өгсөн байна. Тус системийн хэрэглэгч аж ахуйн нэгж байгууллагуудаас 2025 оны системийн хэрэглээний төлбөрийг биржийн дансанд төвлөрүүлэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн Стандарт, хэмжил зүйн газрын шинэ системийг холбох, биржийн цахим тодорхойлолтыг холбох ажлууд хийгдээд явж байна. Систем хэвийн ажиллаж байна.	100%
4.2.2	"Багцын гэрээний НӨАТ систем"-ийн ашиглалт үйлчилгээ;	хувь	Хэрэгжилт	0%	100%					Санхүү мэдээлэл технологийн төвийн И-Баримт 3.0 системтэй тестийн орчинд "Майнд симбол" ХХК-ийг шалгалт өгүүлж тэнцсэн ба Санхүү мэдээллийн технологийн төв, Татварын ерөнхий газар, "Хөдөө аж ахуйн бирж" ХХК хамтарсан гурвалсан гэрээг байгуулснаар Хөдөө аж ахуйн бирж нь мерчант бүртгэх оператор эрхээ авсан. Багцын гэрээний систем дээр "Цэц-Инвест" ХХК брокерийн компаниар зуучуулан тосны ургамлын арилжаанд орсон 2 харилцагч дээр НӨАТ-ийн шивэлт, "Хаан тэлмэн" ХХК брокерийн компаниар зуучуулан арилжаанд орсон 10 харилцагч дээр НӨАТ шивэлтийг үүсгэж тус тус амжилттай илгээсэн. Мөн дуудлага худалдааны хэлцэл дээр НӨАТ үүсгэдэг болсон.	100%
4.2.3	"Агуулах итгэмжлэлийн нэгдсэн систем"-ийн ашиглалт;	хувь	Хэрэгжилт	0%	100%					Агуулахын итгэмжлэлийн нэгдсэн системийг ашиглахад бэлэн болсон. Ашиглалтын явцад сайжруулалт хийх шаардлагатай бол хөгжүүлэгч компанид хүсэлтийг хүргүүлж, сайжруулалт шинэчлэлтийг хийж ажиллана. Домайн нэрийг http://itgemjlel.mce.mn/ болгож өөрчилсөн.	100%
4.2.4	Тоон гарын үсгийг үйл ажиллагаанд нэвтрүүлэх;	хувь	Хэрэгжилт	80%	100%					"Ай түүлс" ХК-д ажлын даалгавар боловсруулан өгч, "Худалдах, худалдан авах гэрээ"-г тоон гарын үсгээр баталгаажуулах ажил нь тухайн ажлын урсгалыг хөнгөөчлөх зорилготой байсан боловч уг компанийн гүйцэтгэл нь ажлын шат дамжлагыг нэмэгдүүлдсэн, ажлын урсгалыг улам төвөгтэй болгож системээс файлыг хуулж авч гарын үсэг зурж, тамга даран буцааж систем рүү хуулах зэрэг механик ажиллагааг ихэсгэсэн тул системд хөгжүүлэлт хийх өөрчлөх шаардлагагүй гэж Гүйцэтгэх захирлын шуурхай журлаар хэлэлцэн шийдвэрлэсэн болно. Санхүүгийн бичиг баримтууд архивт заавал цаасаар хадгалагддаг тул одоогийн нөхцөлд тоон гарын үсгийг хэрэглэх шаардлагагүй гэж үзэж байна.	100%

4.2.5	"Дуудлага худалдааны систем" /cloud.moe.mn/-ийн сайжруулалт, хөгжүүлэлт;	хувь	Хэрэгжилт	80%	100%					Систем хэвийн найдвартай ажиллаж байна. Системд гарсан алдааг цаг тухай бүр засварлуулж ажилласан. Багцын гэрээний систем рүү дуудлага худалдааны хэлцлийн API гаргуулах, Багцын гэрээний системийн сервер дээр OpenVPN суулгуулах ажил дээр GetCustomer GetNegotiationList гэсэн 2 төрлийн Rest API хөгжүүлэн продакшн орчинд байршуулав.	100%
4.2.6	"Худалдааны платформ" /ariljaa.moe.mn/-ийн сайжруулалт, хөгжүүлэлт;	хувь	Хэрэгжилт	0%	100%					Биржийн мал, махны зарын https://ariljaa.moe.mn/ платформын хэвийн үйл ажиллагааг хангаж, нэмэлт сайжруулалтын талаар хөгжүүлэгч компанитай санал солилцсон. Тус платформоор одоогийн байдлаар 239 зар нийтлэгдсэн байна.	100%
4.2.7	"Ажил гүйцэтгэлийн үнэлгээний систем"-ийг нэвтрүүлэх;	хувь	Хэрэгжилт	30%	100%					"Ажил гүйцэтгэлийн үнэлгээний систем"-ээр "ABLE ERP" системийг ашиглаж байна. Тус систем нь байгууллагын удирдлагын үйл ажиллагааг үр дүнтэй, хурдацтай явуулах, удирдах ажлыг хөнгөвчилсөн цахим систем бөгөөд байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, оффисын ажилд зайлшгүй шаардлагатай ажлуудыг цахим хэлбэрт шилжүүлсэн хэд хэдэн программуудаас бүрдсэн нэгдсэн систем юм. Нийт ажилчдыг систем ашиглалтын сургалтанд хамруулж 2025.07.01-ний өдрөөс ашиглаж эхэлсэн.	100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 5. Биржийн зах зээлд оролцогч руу чиглэсэн тэнцвэртэй бодлого хэрэгжүүлэх											
Дэд зорилт 5.1. Биржийн гишүүдийг чадавхжуулах, тэдгээрийг идэвхжүүлэх, нэмэгдүүлэх арга хэмжээг төсөв болон санхүүгийн төлөвлөгөөнд тулгуурлан авч хэрэгжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.											
5.1.1	Байнгын гишүүний гэрээ дүгнэж, сунгах, гишүүнчлэлийн гэрээ байгуулах, идэвхжүүлэх, тэдгээрт арга зүйн зөвлөгөө өгөх;	тоо	Тоо хэмжээ	7	8					Тайлант хугацаанд "Хаан тэлмэн" ХХК, "Ханбүргэд Хантий" ХХК, "Алтаншагай импекс" ХХК, "Цэц Инвест" ХХК болон "Бадархундага Оригл" ХХК-тай байнгын гишүүний гэрээг сунган байгуулсан ба эдгээр компаниуд арилжаанд идэвхтэй оролцож байна. "Мэргэжлийн оролцогч бэлтгэх сургалт" зохион байгуулагдаагүйгээс шалтгаалж байнгын гишүүн шинээр элсүүлээгүй.	63%
5.1.2	Байнгын бус гишүүний гэрээ дүгнэж, сунгах, гишүүнчлэлийн гэрээ байгуулах, идэвхжүүлэх, тэдгээрт арга зүйн зөвлөгөө өгөх, гишүүдийн 10 хувийг хоршоо, үйлдвэр холбосон арилжаанд оролцуулах;	тоо	Тоо хэмжээ	94	200					Биржийн байнгын бус гишүүн оролцогчидтой байгуулсан "Гишүүнчлэлийн гэрээ"-ний хэрэгжилтэд бичиг баримтын шалгалт хийж, бичиг баримтын зөрчилтэй болон гэрээний хүчинтэй хугацаа дууссан байнгын бус гишүүдийн гэрээг дүгнэж, байнгын бус гишүүдийн бүртгэлийг шинэчилсэн. Одоогоор идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй 30 хоршоо биржийн байнгын бус гишүүнээр бүртгэлтэй байна. Эдгээр хоршоодоос биржээр арилжиж буй мал, махны дуудлага худалдаанд идэвхтэй оролцож байна. Цаашид МУЗГ-ын 2022 оны "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 340 дүгээр тогтоолын хүрээнд холбогдох мэргэжлийн холбоотой хамтран "Шинэ хоршоо хөдөлгөөн"-ий хүрээнд үүсгэн байгуулагдсан хоршоодыг чадавхжуулах, идэвхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж биржийн байнгын бус гишүүн хоршоогоор элсүүлэхэд холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллана.	15%
5.1.3	Биржийн гишүүдийг чадавхжуулах, биржийн арилжаанд оролцогчийн эрх олгох, түүнийг сунгах зорилгоор мэргэжлийн оролцогч бэлтгэх сургалт зохион байгуулах;	тоо	Арга хэмжээ	0	1					МУЗГ-ын 2022 оны "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 340 дүгээр тогтоолын хүрээнд МХААГ БТЗЭНМБНХолбоо "Мэргэжлийн оролцогч бэлтгэх сургалт"-ыг зохион байгуулах эрхийг шилжүүлэн авсан. Тус холбоо Санхүүгийн зохицуулах хороотой "Сургалтын гэрээ"-и шинэчлэн байгуулж, сургалтын хөтөлбөрөө батлуулсаны дараа "Мэргэжлийн оролцогч бэлтгэх сургалт"-ыг 2025 оны 11 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөж байсан боловч уг холбоо нь үйл ажиллагаа муу явуулж байгаагаас сургалт зохион байгуулагдаагүй.	100%
5.1.4	Арилжааны зах зээлд оролцогчдыг биржийн барааны код олгогчийн сургалтад хамруулах;	тоо	Арга хэмжээ	0	1					МУЗГ-ын 2022 оны "Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" 340 дүгээр тогтоолын хүрээнд "Биржийн барааны код олгогчийн сургалт"-ыг зохион байгуулах эрхийг мэргэжлийн холбоод нь шилжүүлсэн боловч тус арга хэмжээг зохион байгуулаагүй.	100%
Дэд зорилт 5.2. Малчин, тариалан эрхлэгчдийн оролцоог идэвхжүүлж, арилжаанд оролцох боломжийг төсөв болон санхүүгийн төлөвлөгөөнд тулгуурлан бүрдүүлж, орлогыг нэмэгдүүлнэ.											
5.2.1	"Шинэ хоршоо" хөдөлгөөний хүрээнд үүсгэн байгуулагдсан хоршоодыг чадавхжуулах цахим болон танхим хосолсон сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулж, биржийн байнгын бус гишүүнээр бүртгэн тэдгээрийн бэлтгэсэн бараа, түүхий эдийг биржээр арилжаалах;	тоо	Арга хэмжээ	0	4					1. "Төвийн бүсийн хоршоологчдын зөвлөгөөн"-д Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагааны талаар танилцуулга мэдээлэл өгч, оролцогч хоршоодын төлөөллөөс ирүүлсэн асуултад хариулт өглөө. 2. ЖДҮГ, "Монголын хөдөө аж ахуй хоршоологчдын үндэсний холбоо" ТББ, "Хөдөө аж ахуйн бирж" ХХК, "Хөдөө аж ахуйн корпораци" ХХК, "Зээлийн батлан даалтын сан" хамтран ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын А/164 тушаалаар ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Дархан-Уул, Төв, Сэлэнгэ аймгуудын "Шинэ хоршоо" хөдөлгөөний санхүүжилт авсан хоршоодод зорилтод төсөл хэрэгжүүлэх ажлын хүрээнд мал бордох болон саалийн үнээнд бэлчээрийн маллагаанд нэмэлт тэжээлээр тэжээж өндөр ашиг шим хүртэх зорилгоор төсөл боловсруулахаар ажиллаж байна. Тус аагын хүрээнд бирж нь "Хараахөвч хангай" ХХК-тай "Зөвлөх үйлчилгээний гэрээ" байгуулж, малын тэжээлийн дуудлага худалдааг зохион байгуулсан. 3. Дархан-Уул, Төв, Хантий, Хөвсгөл, Сэлэнгэ, Өвөрхангай аймгуудад зохион байгуулагдсан "Атрын IV аян" хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөгөөнд Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зураглал, биржийн арилжаанд оролцох алхам, үрийн болон хүнсний улаанбуудайн арилжаа, сэлгэн таримлын үрийн арилжааны зураглалын талаар танилцуулга, мэдээлэл олгож, санал солилцлоо. 4. "Арьс ширэн түүхий эд бэлтгэл-2025" төслийн хүрээнд хойд бус, зүүн бус, төвийн бүсэд танхимын хэлбэрээр, баруун бус, говийн бүс, хангайн бүсэд цахим хэлбэрээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, арьс шир бэлтгэл, хадгалалт, түүхий эдийн гэмтэл, анхан шатны тордолт, чанар хангах, биржийн арилжаанд оролцох талаар мэдлэг мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулсан.	100%
5.2.2	Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих "Цагаан алт" хөдөлгөөний хэрэгжилтийн хүрээнд малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжаалах, түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалтыг бий болгож, нийлүүлэлтийн оногчтой тогтолцоог бүрдүүлэх, малчин, түүхий эдийн хоршоо, эрчимжсэн мал ахуй эрхлэгчдийг биржийн үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээллээр тогтмол хангах, бэлтгэсэн бараа, түүхий эдээ биржээр дамжуулан арилжих боломж нөхцөлийг бүрдүүлэх, биржийн арилжаанд татан оролцуулах;	хувь	Хэрэгжилт	0%	100%					"Монголын арьс шир үйлдвэрлэлийн холбоо" ТББ, "Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбоо" ТББ, "Монголын ноос, ноолуурын холбоо" ТББ-уудтай байгуулсан санамж бичгийн дагуу 21 аймагт "Цагаан алт хөдөлгөөн"-ийг сурталчлан таниулах зөвлөлдөх уулзалт зохион байгуулахаар төлөвлөсний дагуу малын гаралтай түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх "Цагаан алт" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх ажлын хүрээнд "Алтан хайч - 2025" арга хэмжээг зохион байгуулсан. Уг арга хэмжээ нь хонины ноосны үнэ цэнийг өсгөх, хаягдалгүй ашиглах, ноосон бүтээгдэхүүний эцсийн үйлдвэрлэлийг дэмжих зорилготой төдийгүй малчдын хөдөлмөрийг хөнгөвчилж, цаг хугацааг хэмнэсэн техник, технологийг нэвтрүүлэх, сурталчлах, таниулах, түүнийг эзэмшсэн залуусыг урамшуулснаараа онцлогтой боллоо. "Арьс ширэн түүхий эд бэлтгэл-2025" төслийн хүрээнд хойд бус, зүүн бус, төвийн бүсэд танхимын хэлбэрээр, баруун бус, говийн бүс, хангайн бүсэд цахим хэлбэрээр төрөөс хэрэгжүүлж буй бодлого, арга хэмжээ, арьс шир бэлтгэл, хадгалалт, түүхий эдийн гэмтэл, анхан шатны тордолт, чанар хангах, биржийн арилжаанд оролцох талаар мэдлэг мэдээлэл олгох сургалтыг зохион байгуулсан.	100%
5.2.3	"Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ыг өрнүүлэхтэй холбогдуулан уламжлалт мал аж ахуй болон эрчимжсэн хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлээр төрөлжих, дотоодын хэрэгцээгээ Монгол орны хөрсөнд ургасан эрүүл хүнсээр бүрэн хангах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор дотоодын үр уржуулах аж ахуйн нэгжүүдийн Супер элит, Элит үрийг биржээр дамжуулан тариалан эрхлэгчдэд нийлүүлэх таатай нөхцөлийг бий болгох боломжийг судалж, арилжааг зохион байгуулах;	хувь	Хэрэгжилт	0%	100%					1. Алсын хараа-2050" МУ-ын урт хугацааны хөгжлийн бодлого, МУЗГ-ын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, "Шинэ сэргэлтийн бодлого", "Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах арга хэмжээний тухай" цогц төлөвлөгөө, "Атрын IV аян" зэрэг бодлого хөтөлбөрийн хүрээнд ХХААХҮЯ-аас зохион байгуулж буй арга хэмжээнд хамтран оролцож байна. Газар тариалангийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг улсын /ахлах/ байцаагч нарын мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтаар биржийн үйл ажиллагааны талаар мэдээлэл өгч, 2025 оны намрын ургацаас хураасан тосны ургамлын дотоодын үйлдвэрт нийлүүлэх болон экспортлох арилжааг биржээр дамжуулан зохион байгуулалттай холбогдуулан авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагааны зураглал, хэрхэн биржээр дамжуулан арилжих талаар мэдээлэл олголоо. 2. 2025 оны намрын ургац хураалтаас улсын нөөцөд бүрдүүлэх зорилгоор Үр үржүүлгийн ААН-ээс худалдан авах үрийн арилжааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.	100%

5.2.4	Тариалан эрхлэгчид болон гурилын үйлдвэр, тэжээлийн үйлдвэрүүдийг биржийн үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээллээр тогтмол хангах, тэдгээрийг чадваржуулах цэцхим болон танхим хосолсон сургалт, зөвлөгөөнийг зохион байгуулах, тэдгээртэй хамтран ажиллах, биржийн арилжаанд татан оруулах	тоо	Арга хэмжээ	0	2					1. Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аяны хүрээнд Хөвсгөл, Төв, Хэнтий, Сэлэнгэ, Өвөрхангай аймгуудын тариаланчдын зөвлөгөөнд оролцож биржийн үйл ажиллагаа болон гадаад, дотоодын арилжааны үйл ажиллагааны зураглалын талаар мэдээлэл өгч нийт 550 гаруй хүнсний улаанбуудай болон төмс, хүнсний ногооны тариаланч нарт мэдээлэл хүргэн ажилласан. 2. 2025 оноос сэлгээнд тариалах тосны ургамал /rapc/-ын дотоодын болон импортын үрийг “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн бүртгэлийн арилжаанд оролцон тариалах, хураасан ургацаас дотоодын үйлдвэрт нийлүүлэх болон экспортлох арилжааг биржээр дамжуулан зохион байгуулахтай холбогдуулан авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үйл ажиллагааны зураглалын талаар экспортын зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдэд танилцуулга мэдээллийг олгох уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тус уулзалтыг ХХААХҮЯ-ны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Салбарын хяналтын газар, МУЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Ургамал хамгааллын газар болон “Хөдөө аж ахуйн корпораци” ТӨХХК хамтран зохион байгуулж, аж ахуйн нэгжүүдтэй харилцан санал солилцлоо. Хурлаар хэлэлцсэн асуудлыг оролцогчид 100 хувь дэмжиж, хурлын тэмдэглэлд гарын үсэг зуран баталгаажуулсан. 3. “Ачит агро” ХХК-ийн импортоор оруулж ирсэн тосны ургамлын үрийг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан худалдан авч тариалсан иргэн, аж ахуйн нэгжүүдийн тариалалтын нөхцөл байдалтай танилцахаар Чинза-5, Чинза-7 сортын тосны ургамлын үр нийлүүлэгч БНХАУ-ын аж ахуйн нэгжийн төлөөлөл тосны ургамал тариалалтын мэргэшсэн агрономич нарын хамтаар Монгол Улсад хүрэлцэн ирж тариалангийн талбай тус бүрийн тариалалтын нөхцөл байдалтай танилцаж, ургацын онцлогт тохирох арчилгаа тордолгоо, авч хэрэгжүүлэх арга технологийн зөвлөмжүүдийг тариалан эрхлэгчдэд өгч, мэдээлэл солилцон ажиллалаа. Энэ үеэр Хөдөө аж ахуйн биржээс тариалан эрхлэгчдэд 2025 оноос сэлгээнд тариалах тосны ургамал дотоодын болон импортын үрийг биржийн бүртгэлийн арилжаанд оролцон тариалах, хураасан ургацаас дотоодын үйлдвэрт нийлүүлэх болон экспортлоходоо биржээр дамжуулан зохион байгуулахтай холбогдуулан төрөөс авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээ, тосны ургамлын биржийн арилжааны талаар зөвлөгөө мэдээлэл өглөө. 4. ХХААХҮЯ-ний Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/216 дугаар тушаалаар 2025.07.01-07.09-ний өдрүүдэд Төвийн бүс, Зүүн бүс, Баруун бүсийн аймгийн 18 сумдад ажиллах ажлын хэсэгт хамрагдан тариаланч нартай тариан талбай дээр очиж уулзалт хийлээ. Албан томилолтын үеэр тариалалтын эхний урьдчилсан баланс болон биржээр дамжуулан худалдан авсан үрийн ургалтын байдалтай танилцаж, намарын ургац хураалтаас хураасан хүнсний болон үрийн улаанбуудай, тосны ургамал /rapc/-ыг хэрхэн биржээр дамжуулан арилжаалах талаар мэдээлэл, заавар зөвлөгөө өгч ажиллалаа.	100%
Дэд зорилт 5.3. Гадаад болон дотоодын худалдан авагч, үйлдвэрүүдийг биржийн арилжаанд оролцох тэгш боломжоор хангах нөхцлийг											
5.3.1	Дотоодын худалдан авагч, үйлдвэрүүдийг биржийн арилжаанд оролцох таатай нөхцлөөр хангаж, арилжаанд татан оролцуулах арга замыг тодорхойлох	тоо	Арга хэмжээ	0	1					Гүйцэтгэх захирлын 2025 оны А/22 дугаар тушаалаар “Компанийн 2025 оны Бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хэсэг”-ийг байгуулсан. Ажлын хэсэг компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хуулийн 4.5, 4.6 дахь хэсгийг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын баталсан биржээр арилжих барааны жагсаалтад буй бараа, түүхий эдийн зах зээлийн судалгааг хийж, тэдгээрийг биржээр дамжуулан арилжихад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлох судалгааг хийж танилцуулсан.	100%
5.3.2	Гадаадын худалдан авагчдыг биржийн арилжаанд оролцох боломжийг судалж, татан оролцуулах арга замыг тодорхойлох	тоо	Хэрэгжилт	0	1					1. “Монгол-Өвөр Монголын Бизнесийн холбоо”-той гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх уулзалт хийлээ. Тус уулзалтаар Хөдөө аж ахуйн биржээр арилжаалагдах 8 нэр төрлийн бараа, түүхий эдийн арилжааны зураглал, Өвөр Монгол дахь худалдан авагчдыг биржийн арилжаанд татан оролцуулах боломжийн талаар танилцуулж, цаашдын хамтын ажиллагааг эхлүүлэх алхамыг хэрэгжүүлсэн. 2. МҮХАҮТ-ын гишүүн болсонтой холбогдуулан хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг гадаад зах зээлд экспортлох, гадаадын худалдан авагч байгууллагуудтай харилцаа холбоо тогтоох, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд МҮХАҮТ-иар дамжуулан гадаадын Худалдаа, аж үйлдвэрийн танхимуудтай холбоо тогтоох замаар хамтран ажиллах хүсэлтийг албан бичиг танхимд хүргүүлсэн. 3. 2025.08.18-ны өдөр МҮХАҮТ-д болох Монгол-Японы олон улсын бизнес инновацын форумд хөдөө аж ахуйн гаралтай таваарын биржийн үйл ажиллагаа нь олон улсын жишигт нийцсэн Япон улсын таваарын бирж болох Osaka Exchange (OSE)-ийг оролцуулахад дэмжлэг үзүүлэн ажиллах тухай албан хүсэлтийг МҮХАҮТ-д хүргүүлсэн бөгөөд Япон талаас хариу хүлээж байна.	100%
Стратеги төлөвлөгөөний зорилго 6. Биржийн дэд бүтцийг сайжруулах											
Дэд зорилт 6.1. Биржийн итгэмжлэгдсэн этгээдийн оролцоог нэмэгдүүлж, идэвхжүүлэн ложистикийн үйл ажиллагааг сайжруулна.											
6.1.1	Бүсчилсэн хөгжлийн бодлогын дагуу биржээр арилжих бараа, түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтийн ложистикийн сүлжээг бий болгох зорилгоор орон нутагт биржийн салбар нэгж, төлөөлөгчийн газрыг байгуулах арга замыг тодорхойлж, танилцуулах	тоо	Баримт бичиг	0	1					Орон нутагт биржийн салбар нэгж, төлөөлөгчийн газрыг бий болгохдоо малын тоо толгой, түүхий эдийн гарцын хэмжээнд тулгуурлан тухайн орон нутагт тогтвортой үйл ажиллагаа явуулдаг хоршоо болон агуулахад суурилсан байхад анхаарч УИХ-ын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, “Шинэ хоршоо” хөдөлгөөнтэй уялдуулах, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг эрэлхийлж байна. Үүний хүрээнд “Монголын хөдөө аж ахуйн хоршооллогчдын үндэсний холбоо” ТББ-тай хамтран ажиллах санал солилцсон. Хөдөө аж ахуйн биржид бүтцийн өөрчлөлт орсон тохиолдолд орон нутагт биржийн салбар нэгж, төлөөлөгчийн газартай болох эсвэл бүсчлэлийн дагуу биржийн үйл ажиллагааг эрхлэх төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах нөхцөл боломжийг эрэлхийлэн ажиллаж байна.	80%
6.1.2	Үйлдвэрийн дэргэдэх итгэмжлэгдсэн агуулахуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх, нэмэгдүүлэх	тоо	Агуулахын тоо	25	27					МУЗГ-ын 2025 оны 19 дүгээр хуралдааны тэмдэглэлд тусгасан зах зээл дээрх ноолуурын худалдан авалтыг дэмжиж, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор энгийн вексель гаргахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан “Ханбогд кашимир” ХХК болон “Говь” ХХК-иудын түүхий эдийн агуулахыг итгэмжилж “Итгэмжлэлийн гэрээ” байгуулсан. Хөдөө аж ахуйн бирж нь тус арга хэмжээнд векселиэр худалдан авсан ноолуурын баталгаажуулалт, бүртгэлд хяналт тавих үүргээр оролцсон. Биржийн итгэмжлэл авч “Итгэмжлэл олгох гэрээ” байгуулсан үйлдвэрийн дэргэдэх агуулахуудад бичиг баримтын шалгалт хийж, бичиг баримтын зөрчилтэй болон гэрээний хүчинтэй хугацаа дууссан агуулахуудын гэрээг дүгнэж, итгэмжлэгдсэн этгээдийн бүртгэлийг шинэчилсэн. Одоогоор идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрийн дэргэдэх 20 агуулах бүртгэлтэй байна.	74%
6.1.3	Орон нутгийн итгэмжлэгдсэн агуулахуудын үйл ажиллагааг идэвхжүүлж, нэмэгдүүлэх	тоо	Агуулахын тоо	120	125					Биржийн итгэмжлэл авч “Итгэмжлэл олгох гэрээ” байгуулсан орон нутаг дахь түүхий эдийн агуулахуудад бичиг баримтын шалгалт хийж, бичиг баримтын зөрчилтэй болон гэрээний хүчинтэй хугацаа дууссан агуулахуудын гэрээг дүгнэж, итгэмжлэгдсэн этгээдийн бүртгэлийг шинэчилсэн. Одоогоор идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хоршооны дэргэдэх 4 агуулах бүртгэлтэй байна.	3%
Дэд зорилт 6.2. Ложистикийн төвийн үйл ажиллагааг төсөв болон санхүүгийн төлөвлөгөөнд тулгуурлан идэвхжүүлнэ. Малын гаралтай бараа, түүхий эдийн танхимын арилжаа, амьд малын спот арилжааг дуудлага худалдааны хэлбэрээр зохион байгуулах үйл ажиллагааг явуулна.											
6.2.1	Ложистикийн төвийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардлагатай тордолт, засвар үйлчилгээг цаг тухай бүр хийж гүйцэтгэх	тоо	Хэрэгжилт	0	1					2025.07.24-07.25-нд шилжих шөнө байгалийн онц ноцтой үзэгдэл болсонтой холбогдуулан Ложистикийн төвийн махны хөргүүртэй агуулахын дээвэр хийссэн байсныг 2025.08.01-ний өдөр засварлаж үйл ажиллагааг хэвийн байдалд шилжүүлсэн. Тус байгууламжид цэвэрлээ хийж, хуримтлагдсан хогийг ачуулаад байна. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх, хөдөө аж ахуйн салбарыг шинэ шатанд хүргэх зорилгоор Япон Улсын “Озава Тент” ХХК-тай хамтран ажиллах уулзалт хийлээ. Уулзалтын хүрээнд мембран материалыг ашиглан агаарын давхарга үүсгэх технологид суурилсан өндөр чанарын агуулахыг Монгол Улсын зах зээлд нэвтрүүлэх, туршилтын төслийг хамтран хэрэгжүүлэхээр хэлэлцэж, Ложистикийн төвийн хашаанд “Озава Тент” ХХК-ийн санхүүжилтээр малын гаралтай түүхий эд хадгалах туршилтын агуулахыг барих барилгыг 2025.10.07-ны өдөр хүлээлгэн өглөө. Тус тентэн агуулах нь мембран материалыг ашиглан агаарын давхарга үүсгэх технологид суурилсан өндөр чанарын агуулах бөгөөд -40 градуст тэсвэртэй, барихад хялбар гэдгээрээ онцлогтой.	100%
6.2.2	Ложистикийн төвд амьд мал болон малын гаралтай бараа, түүхий эдийн арилжааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангаж, арилжааг зохион байгуулах	тоо	Арга хэмжээ	0	2					Ложистикийн төвийн хөргүүрт хадгалагдаж байсан “Ашид мөнх баян” хоршооны 273 сая төгрөгийн 26 тонн хонины гулууз мах, 130 сая төгрөгийн 10 тонн үхрийн махны дуудлага худалдааг амжилттай зохион байгууллаа. Энэхүү дуудлага худалдаанд “Сочо шимт” ХХК ялагч болж худалдан авалтыг хийсэн. “Ашид мөнх баян” хоршооны дуудлага худалдаагаар арилжсан махыг 2024 оны 12 дугаар сард Ложистикийн төвийн махны хөргүүрт хадгалсан.	50%

90%

Гүйцэтгэх төлөвлөгөөт ажил

63

Гүйцэтгэлийн үнэлгээ

90%

Нийт гүйцэтгэсэн ажлын тоо

59